

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ	4
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
1.1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл	4
1.1.2 Төслийн байршил, газар ашиглалтын тодорхойлолт	4
1.2 Ашигт малтмалын ордын тодорхойлолт	5
1.2.1 Геологийн нөөц баялаг.....	5
1.2.2 Ордын нөөцийн тооцоо.....	6
1.3 Үйлдвэрийн нөөцийн тооцоо	7
1.3.1 Уурхайн жилийн хүчин чадал, ашиглах хугацаа ба ажиллах горим	8
1.4 Олборлолт	9
1.4.1 Ил уурхайн хил хязгаар, уулын ажлын хэмжээ.....	9
1.4.2 Ордын нээлт	10
1.5 Баяжуулалт	21
1.5.1 Баяжуулах технологи	21
1.5.2 Баяжуулах цехийн ажиллах горим, хүчин чадал.....	21
1.6 Дэд бүтэц.....	23
2. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	26
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	31
3.1 Төслөөс үзүүлэх сөрөг нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүд	31
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	34
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	35
4.2 Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөлөө.....	42
4.3 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	43
4.4 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө:.....	43
4.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	44
4.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	46
4.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	49
4.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	51
4.9 Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	52

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг.....	5
Зураг 2 Ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбайн зураг	5
Зураг 3. Ил уурхайн хил хязгаар	10
Зураг 4. 3-В хэсэгшлийг нээх схем	11
Зураг 5. Ашиглалтын эхний жилийн уулын ажлын эцсийн байдал	14
Зураг 6. Ашиглалтын 2 дахь жилийн уулын ажлын эцсийн байдал.....	17
Зураг 7. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө	20

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. MV-022818 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүд	4
Хүснэгт 2. Ордын нөөцийн тооцооны үр дүн.....	6
Хүснэгт 3. Ашиглалтанд өртөхгүй нөөц	7
Хүснэгт 4. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцооны нэгдсэн дүн.....	8
Хүснэгт 5. Уулын ажлын горим.....	9
Хүснэгт 6. Уулын ажлын хэмжээ.....	9
Хүснэгт 7. Ордын нээлтийн үндсэн ажлын хэмжээ	11
Хүснэгт 8. Ашиглалтын эхний жилийн уулын ажлын тооцоо.....	13
Хүснэгт 9. Ашиглалтын 2 дахь жилийн уулын ажлын хэмжээ.....	15
Хүснэгт 10. Ашиглалтын 3 дахь жилийн уулын ажлын тооцоо	18
Хүснэгт 11. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө.....	19
Хүснэгт 12. Баяжуулах цехийн ажиллах горим.....	21
Хүснэгт 13. Байгаль орчны сөрөг нөлөөллийн үзүүлэлтүүд.....	31
Хүснэгт 14. 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал	34
Хүснэгт 15. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ.....	35
Хүснэгт 16. Биологийн нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ	42
Хүснэгт 17. Биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардал	42
Хүснэгт 18. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	43
Хүснэгт 19. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	44
Хүснэгт 20. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	46
Хүснэгт 21. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	49
Хүснэгт 22. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	51

1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

1.1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл

Төслийн нэр :	“Манж толгой” алтны бүлэг шороон ордыг ил аргаар ашиглах төсөл
Төсөл хэрэгжүүлэгч :	“Ривади” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011099048 Регистрийн дугаар: 2048221 Хариуцлагын хэлбэр “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” Тусгай зөвшөөрлийн дугаар : MV-022818
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар, Баянзүрх, 17-р хороо, 157 тоот Утас: 99113436

1.1.2 Төслийн байршил, газар ашиглалтын тодорхойлолт

Төсөл хэрэгжүүлэгч субъект болох “Ривади” ХХК нь Монгол улсын Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт оршдог. Тус орд нь Улаанбаатар хотоос баруун урагш 710 км-т, Баянхонгор аймгийн төвөөс баруун хойш 70 км-т, Баян-Овоо сумаас баруун хойш 38 км-т, Галуут сумаас баруун урагш 40 км-т байрлана.


- Талбайн хэмжээ: 884.19 га
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-47-57, L-47-69

Газарзүйн солбицол:


Хүснэгт 1. MV-022818 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүд

№	Эзэмшлийн Талбайн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Эргэлийн цэгийн дугаар	Уртлаг			Өргөрөг		
				Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	Ривади ХХК Цахир худагт талбай	MV-022818	1	46	21	31.57	100	7	32
2			2	46	20	32	100	7	32
3			3	46	20	32	100	8	33.5
4			4	46	18	46.25	100	8	33.5
5			5	46	18	46.25	100	7	40.5
6			6	46	20	1.57	100	7	40.5
7			7	46	20	1.57	100	6	10.5
8			8	46	20	31.57	100	6	10.5
9			9	46	20	31.57	100	6	25.5
10			10	46	21	51.58	100	6	25.5
11			11	46	21	51.58	100	7	20.5
12			12	46	21	51.58	100	7	20.5

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших “Ривади” ХХК-ийн “Манж толгой” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 1. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн байршилн зураг



Зураг 2 Ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбайн зураг

1.2 Ашигт малтмалын ордын тодорхойлолт

1.2.1 Геологийн нөөц баялаг

2023 онд эрэл-хайгуулын ажил гүйцэтгэж, хоорондоо (0.3-1.0 км) орших Бааст, Яст, Баруун, Цогт, Хүрэн, Хавтгай, Манж, Өвөр, Тогоот, Чулуут зэрэг алтны бүлэг шороон ордын хуримтлал үүссэнийг тогтоосон.

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших “Ривади” ХХК-ийн “Манж толгой” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2023 оны гүйцэтгэсэн эрэл, хайгуулын ажлын үр дүнгийн нөөцийн тооцоог Эрдэс баялаг, эрчим хүчний яамны ЭБМЗ-өөр хэлэлцүүлж, 2024 оны 03-р сарын 07-ны өдрийн ХХ-02-05 тоот, АМГТГ-ын даргын 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн тушаалаар ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүрдгэлд бүртгүүлжээ. Манж толгойн алтны шороон ордын В+С зэрэглэлийн элсний нөөц 382.3 мян.м³, алт 64.3 кг.

1.2.2 Ордын нөөцийн тооцоо

Ордын нөөцийн тооцоог Уул уурхайн сайдын 2015 оны 203 тоот тушаал “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”, 2019 оны А/193-р тушаал “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийн дагуу тооцоолсон.

Нөөцийн тооцооны жишиг үзүүлэлтүүд.

- Алхам дахь доод агуулга ≥ 50 мг/м³
- Блок дахь захын малталтын хамгийн бага агуулга ≥ 50 мг/м³
- Блок дахь үйлдвэрлэлийн хамгийн бага агуулга ≥ 50 мг/м³
- Ашигт давхаргын хамгийн бага зузаан - 0.4 м
- Давхарга дахь ядуу агуулгатай < 50 мг/м³
- Хоосон хэсгийн зузаан - 0.8 м
- Ашигт давхаргын хамгийн бага өргөн - 20 м.

Хайгуулын ажлын үр дүнгийн тайлангаар нийт бодитой болон боломжтой /В+С/ зэрэглэлээр 382.3 мян.м³ элс, 180 мг/м³ дундаж агуулгатай шлихээр 68.36 кг металл, химийн цэврээр 64.26 кг металлын нөөцийг тооцоолж, 2024 оны 04-р сарын 05-ны өдрийн Н/11 тоот УГА-ын даргын тушаалаар баталсан байна.

Хүснэгт 2. Ордын нөөцийн тооцооны үр дүн

Дд	Хэсгийн нэр	Нөөцийн зэрэглэл	Зузаан, м		Дундаж агуулга мг/м³	Талбай мян.м²	Эзлэхүүн, мян.м³		Металл, кг (шлих)	Металл, кг (цэвр)
			хөрс	элс			Хөрс	Элс		
1	Хүрэн жалга	В	0.4	0.9	250.0	112.21	47.05	100.05	25.79	24.2
		С	2.0	0.6	80.0	36.32	62.32	39.33	3.38	3.17
		Дүн В+С	0.8	1.0	200.0	148.53	109.37	139.38	29.17	27.37
2	Цогт жалга	В	1.0	0.9	200.0	56.89	78.99	46.39	7.21	6.78
		С	0.9	1.3	230.0	36.48	48.12	37.37	5.90	5.54
		Дүн В+С	1.0	1.1	210.0	93.37	127.11	83.76	13.11	12.32
3	Яст жалга	В	0.7	0.7	130.0	20.53	20.81	13.13	1.84	1.73
		С	1.5	0.7	190.0	6.58	8.41	4.81	0.75	0.70
		Дүн В+С	1.1	0.7	140.0	27.11	29.22	17.94	2.59	2.43
4	Чулуут жалга	С	2.3	0.7	200.0	52.90	123.66	39.60	7.84	7.36
5	Бааст жалга	В	1.0	1.3	200.0	2.92	2.35	3.00	0.61	0.57
		С	0.6	0.8	120.0	16.61	11.50	9.24	0.96	0.90
		Дүн В+С	0.7	0.9	140.0	19.53	13.85	12.25	1.57	1.47
6	Манж дэнж	В	3.0	0.7	220.0	42.28	126.12	31.00	6.74	6.34
		С	2.5	0.9	80.0	13.83	32.79	12.39	1.01	0.95
		Дүн В+С	2.8	0.8	150.0	56.11	158.91	43.39	7.75	7.29
7	Хавтгай дэнж	В	2.8	1.2	180.0	5.40	15.12	6.48	1.16	1.09
		С	1.4	0.8	260.0	4.36	6.02	3.49	0.89	0.83
		Дүн В+С	2.2	1.0	210.0	9.76	21.14	9.97	2.05	1.93
8	Өвөр дэнж	С	3.8	0.4	110.0	16.84	67.05	7.39	0.73	0.70
9	Тогоот дэнж	С	2.3	0.4	120.0	42.22	97.18	17.60	2.13	1.97

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших “Ривади” ХХК-ийн “Манж толгой” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

10	Баруун жалга	В	1.3	0.9	130.0	6.72	8.74	6.05	0.78	0.74
		С	1.5	1.1	130.0	4.75	6.90	5.00	0.65	0.60
		Дүн В+С	1.4	1.0	130.0	11.47	15.64	11.05	1.43	1.34
Дүн-В					214.0	246.95	299.18	206.09	44.16	41.51
Дүн-С					138.0	230.90	463.94	176.22	24.20	22.75
Дүн-В+С			1.6	0.8	180.0	477.85	763.12	382.31	68.36	64.26

1.3 Үйлдвэрийн нөөцийн тооцоо

Манж толгойн бүлэг шороон ордын зарим хэсгийн хил нь тусгай зөвшөөрлийн хилтэй давхцаж байна. Иймд ашиглалтын тусгай зөвшөөрлийн хилийн шугамаар хязгаарлагдсан ил уурхайн хүрээний гадна хэсэгт ашиглалтанд өртөхгүй нөөц орхигдож байна. Хүрэн жалгын ордын 1-С хэсэгшлийн зүүн жигүүр, Яст жалгын ордын 2-С хэсэгшлийн баруун жигүүр, Баруун жалгын ордын 2-С хэсэгшлийн урд жигүүр, Цогт жалгын ордын 2-С хэсэгшлийн урд жигүүрийн нөөцийн хил нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн хилтэй давхцах ба Чулуут жалгын орд бүхэлдээ ашиглалтын тусгай зөвшөөрлийн хилийн гадна байна. Иймд тодорхой хэмжээний нөөц ашиглалтанд өртөхгүй үлдэх ба хэмжээг тооцоолон хүсн.№ II.1-д үзүүлэв. Ашиглалтанд өртөхгүй нийт нөөц боломжтой (С) зэрэглэлээр 41.8 мян.м³ элс, 192 мг/м³ дундаж агуулгатай шлихээр 8.02 кг алт үлдэж байна.

Хүснэгт 3. Ашиглалтанд өртөхгүй нөөц

Ордын нэр	Хэсэгшлийн дугаар	Хэсэгшлийн талбай, м²	Элсний эзлэхүүн, м³	Дундаж агуулга, мг/м³	Металл, кг /шлих/
Хүрэн жалга	1-С	545	381	170	0.06
	5-С	2346	938	60	0.06
	6-С	2000	800	60	0.05
Баруун жалга	2-С	2	3	140	0.0004
Цогт жалга	2-С	63	63	150	0.01
Яст жалга	2-С	45	36	100	0.004
Чулуут жалга	1-С	12542	5017	370	1.85
	2-С	13440	5376	190	1.02
	3-С	15460	17006	150	2.55
	4-С	8460	10998	150	1.64
	5-С	3000	1200	650	0.78
Нийт		57902	41818	192	8.02

Хаягдал, бохирдлын тооцоо. Ордуудын ашигт давхаргын тааз, улны тэгш бус тогтоц, тоног төхөөрөмжийг ажиллуулж буй операторчдын ур чадвар, ашигт малтмалын үнэ цэнэ, олборлолтын арга зэргийг үндэслэн хаягдал, бохирдлын хувь хэмжээг тооцоолов.

Ашиглалтын үеийн хаягдал: Экскаватороор утгаж ачихад ашигт давхаргын тааз улнаас болон тээвэрлэлтийн явцад хаягдал гардаг ба хаягдлыг манай орны бусад ижил төстэй алтны уурхайнуудын жишгээр тооцож, 1 %-иар авав.

Ашиглалтын үеийн бохирдол: Ашигт малтмалыг хаягдал багатай олборлохын тулд ашигт давхаргын дээрх хучаас хөрсний улнаас 0.15 м, ашигт давхаргын улны цэвэрлэгээг 0.1 м зузаанаар тааз, улнаас бохирдох ба уурхайн хажуугаас мөн бохирдоно гэж үзэв. Орд тус бүрт хаягдал ба бохирдлын хэмжээ харилцан адилгүй байна. Хаягдал, бохирдолтын тооцооны үр дүнг хүснэгт үзүүлэв.

Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо. УУСайдын 2015 оны 203-р тушаалд заасан ангиллын дагуу III бүлгийн ордын ил уурхайн хил хязгаар доторх геологийн бодитой (В) болон боломжтой (С) зэрэглэлээр үнэлэгдсэн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан (В')

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших “Ривади” ХХК-ийн “Манж толгой” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

зэрэглэлд шилжүүлж тооцлоо. Үйлдвэрлэлийн нөөцийг хэсэгшил тус бүрээр нь хаягдал бохирдлын хувь хэмжээнд үндэслэн тооцоолов. Үйлдвэрлэлийн нийт нөөцийн тооцооны хураангуйг хүсн.№3-т үзүүлэв. Хүснэгтээс үзэхэд үйлдвэрлэлийн нөөцийн тооцоонд элсний бохирдлыг таазнаас 0.15 м, улнаас 0.1 м болон мөн хажуугаас орох бохирдлыг тооцоолоход нийт элсний бохирдол 104.7 мян.м³ буюу дунджаар 31.06 %-иар бохирдож байна.

Уурхайн ашиглалтын үеийн нийт хаягдал 1.0 % буюу 3.40 мян.м³ элс, шлихээр 0.61 кг алт хаягдаж байна.

Үйлдвэрлэлийн магадалсан (В') зэрэглэлээр 135.0 мг/м³ дундаж агуулгатай 441.8 мян.м³ элс, шлихээр 59.73 кг, цэврээр 56.15 кг алтны нөөц байна.

Хүснэгт 4. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцооны нэгдсэн дүн

Ордын нэр	Нөөцийн зэрэглэл	Үйлдвэрлэлийн нөөц, м³		Дундаж агуулга, %	Металл, кг	
		хөрс	элс		шлих	цэвэр
Хүрэн жалга	В	51400.0	125785.9	203	25.53	24.00
	С	55540.9	44534.4	71	3.18	2.99
	Нийт	106941.0	170320.2	169	28.71	26.99
Баруун жалга	В	10034.9	7733.7	100	0.78	0.73
	С	8032.9	6237.6	102	0.64	0.60
	Нийт	18067.9	13971.3	101	1.42	1.33
Тогоот дэнж	С	103002.8	28054.3	75	2.10	1.98
Цогт жалга	В	82337.9	60281.3	118	7.14	6.71
	С	50672.4	46217.7	126	5.83	5.48
	Нийт	133010.3	106499.0	122	12.97	12.19
Яст жалга	В	25280.4	18199.1	100	1.83	1.72
	С	12175.6	6393.0	115	0.73	0.69
	Нийт	37456.0	24592.2	104	2.56	2.41
Бааст жалга	В	2825.0	3765.3	161	0.61	0.57
	С	12214.3	13383.2	71	0.95	0.89
	Нийт	15039.3	17148.5	91	1.55	1.46
Манж дэнж	В	133195.9	41366.7	161	6.68	6.28
	С	38259.1	15851.0	63	0.99	0.94
	Нийт	171455.1	57217.7	134	7.67	7.21
Хавтгай дэнж	В	15644.5	7834.7	147	1.15	1.08
	С	6787.4	4578.4	192	0.88	0.82
	Нийт	22431.9	12413.1	163	2.03	1.91
Өвөр дэнж	С	69602.0	11554.1	62	0.72	0.68
Ордын хэмжээнд	В	320718.7	264966.6	165	43.71	41.09
	С	356287.5	176803.7	91	16.02	15.06
	Нийт	677006.1	441770.3	135	59.73	56.15

1.3.1 Уурхайн жилийн хүчин чадал, ашиглах хугацаа ба ажиллах горим

Ашиглалтын хугацаа: Захиалагчийн өгсөн техникийн даалгаврын дагуу уг төслийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Жилийн хүчин чадал: Ордын нөөцийн хэмжээ, ашиглах хугацаа, өөрийн тоног төхөөрөмжүүдийн хүчин чадалтай уялдуулж жилийн хүчин чадлыг тогтоов.

Үйлдвэрлэлийн нөөц, ашиглалтын хугацаа, өөрийн тоног төхөөрөмжүүдийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулахад жилд олборлох элсний хэмжээ 175.0 мян.м³ байна. Иймд төслийн жилийн хүчин чадлыг 175.0 мян.м³ элс гэж тогтоов.

Ажиллах горим: Тус талбайн ойр орчимд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэлийн ажиллах горим, газар зүйн байрлал, дүүргийн уур амьсгалд үндэслэн ажиллах горимыг тогтоов. Цаг уурын сүүлийн үеийн мэдээг (www.bayan-hongor-tsag-agaar.gov.mn) авав.

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших “Ривади” ХХК-ийн “Манж толгой” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Энэхүү нөхцөлийг үндэслэж, дулааны улирлын 5-р сарын 20-оос эхлэн 10-р сарын 1 хүртэл 4 сарын хугацаанд 12 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжээр уулын ажлыг явуулна. Уулын ажлын горимыг хүснэгт 6-т үзүүлэв.

Хүснэгт 5. Уулын ажлын горим

Ажиллах сар	Календарын хоног	Амралт, сул зогсолт, хон			Ажиллах хоног	Хоногт ажиллах ээлжийн тоо	Ажиллах цаг
		нийтээр тэмдэглэх баярын өдөр	цаг агаарын хүндрэл тооцох	засвар, үйлчлгээ			
5	11	0	0	0	11	1	132
6	30	1	0	0	29	1	348
7	31	5	0	1	25	1	300
8	31	0	2	2	27	1	324
9	30	0	2	0	28	1	336
Нийт	133	6	4	3	120		1440

1.4 Олборлолт

1.4.1 Ил уурхайн хил хязгаар, уулын ажлын хэмжээ

Манж толгой нэртэй бүлэг шороон орд нь 10 хэсэг талбайд байрлах ордуудаас бүрдэх ба ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хилээр хязгаарлагдах ил уурхайн хүрээгээр хил хязгаарыг тогтоов.


Орд тус бүрийн нөөцийн хэсэгшлийн хилийн шугамаар үүсгэсэн ил уурхайн дээд хүрээгээр хил хязгаарыг, ил уурхайн гүнийг тогтоосон элсний давхаргын улаар байгуулав.

Уулын ажлын тооцоог хүснэгт 3-д үзүүлэв. Ил уурхайн ашиглалтын эцсийн байдлыг хавсралт зурагт, ил уурхайн ерөнхий байдлыг зураг 4-д тус тус үзүүлэв.

Ашиглалтын хугацаанд нийт 486.7 мян.м² талбайд уулын ажлыг явуулж, нийт 677.0 мян.м³ хөрс хуулж, 441.8 мян.м³ элс олборлох ба хөрс хуулалтын дундаж коэффициент 1.53 м³/м³ байна.

Хүснэгт 6. Уулын ажлын хэмжээ

Ордын нэр	Ил уурхайн хэмжээсүүд				Хөрс хуулалт, мян.м ³	Элс олборлолт, мян.м ³	Хөрс хуулалтын коэффициент, м ³ /м ³
	дундаж урт, м	дундаж өргөн, м	дундаж гүн, м	талбай, мян.м ²			
Хүрэн жалга	2268	70	1.8	166.3	106.9	170.3	0.63
Баруун жалга	413	38	2.5	15.8	18.1	14.0	1.29
Тогоот дэнж	1118	50	2.7	50.3	103.0	28.1	3.67
Яст жалга	547	67	1.8	35.3	37.5	24.6	1.52
Цогт жалга	1010	160	2.1	101.4	133.0	106.5	1.25
Хавтгай дэнж	265	46	3.2	11.6	22.4	12.4	1.81
Манж дэнж	938	61	3.6	62.8	171.5	57.2	3.00
Бааст жалга	490	48	1.6	23.9	15.0	17.1	0.88
Өвөр дэнж	393	50	4.2	19.3	69.6	11.6	6.02
Нийт				486.7	677.0	441.8	1.53



Зураг 3. Ил уурхайн хил хязгаар

1.4.2 Ордын нээлт

Манж толгой нэртэй бүлэг шороон ордын 9 нь ашиглагдана. Орд тус бүрт нээлт хийх ба хамгийн эхэнд ашиглалт явуулах ордын нээлтийг төлөвлөж, төсөлд тусгав. Ашиглах

дараалал бүлэгт тусгаснаар ордыг хамгийн эхэнд ашиглахад уул-техникийн болон эдийн засгийн хувьд ач холбогдолтой нь Хүрэн жалгын орд байна.


Нээх талбайн мэдээлэл. Тус ордын нөөцийн хэсэгшлүүдээс хамгийн өндөр агуулгатай, маш бага хөрс хуулалттай 3-В хэсэгшлийг нээхээр төлөвлөв. 3-В хэсэгшил нь дунджаар 213 м урт, 103 м өргөн, хучаас хөрсний зузаан дунджаар 0.3 м, элсний зузаан 1.5 м, агуулга 340 мг/м³ байна. Талбайн гадаргуу нь зүүн хойд зүгээс зүүн урд зүг рүү $i = 0.023$ налуутай байна.

3-В хэсэгшлийг нээх. Хайгуулын шугам 20-20 дагуу 30 м өргөнөөр шимт хөрсийг (0.2 м) бульдозероор хуулахад авахад бэлэн элсний нөөцийн тааз нээгдэнэ. Шимт хөрсийг хуулахдаа ил уурхайн баруун, зүүн талын ирмэгийг дагуулан овоолно. Нээсэн талбайн хэмжээ 3082 м², уулын үндсэн ажлын хэмжээ 616.4 м³, авахад бэлэн элсний нөөцийн хэмжээ 4623.0 м³, алтны хэмжээ 1.57 кг байна.

Ордын нээлтийн ажлын хэмжээг тооцоолон хүснэгт 8-д, ордыг нээх уулын ажлын байдлыг зур 6-д тус тус үзүүлэв.

Хүснэгт 7. Ордын нээлтийн үндсэн ажлын хэмжээ

Хэсэгшлийн дугаар	Дундаж талбай, м ²	Зузаан, м		Хөрс хуулалт, м ³	Авахад бэлэн нөөц, м ³	
		хөрс	элс		элс	металл
3-В	3082	0.2	1.5	616.4	4623.0	1.57



Зураг 4. 3-В хэсэгшлийг нээх схем

Ашиглах дараалал

Бүлэг ордоор. “Манж толгой” нэртэй бүлэг алтны шороон ордын ашиглах дарааллыг тогтоохдоо хучаас хөрсний зузаан, металлын агуулга ба хэмжээ зэргийг үндэслэн тогтоов.

- Хучаас хөрсний зузаан багатай нь Хүрэн жалга, Цогт жалга, Бааст жалгын орд,
- Металлын агуулга өндөртэй нь Хүрэн жалга, Цогт жалга, Хавтгай дэнжийн орд,

- Металлын хэмжээ ихтэй нь Хүрэн жалга орд.

Дээрх үзүүлэлтүүдээс үзэхэд хамгийн эхэнд Хүрэн жалга, дараа нь Цогт жалга, Бааст жалга, Хавтгай дэнж гэсэн дарааллаар үнэлэгдэж байна.

Иймд Хүрэн жалгын ордоос эхэлж ашиглана. Дараа нь Цогт жалгын ордыг ашиглах ба түүний ойр орчмын Яст жалгын орд, Баруун жалгын орд, Тогоот дэнжийн ордыг ашиглаж дуусгаад ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хойд хэсэгт байрлах ордуудыг ашиглахаар төлөвлөн, дараах байдлаар ашиглах дарааллыг тогтоов.

Хүрэн жалга → Цогт жалга → Яст жалга → Баруун жалга → Тогоот дэнж →
Өвөр дэнж → Бааст жалга → Манж дэнж → Хавтгай дэнж

Нөөцийн хэсэгшлээр. Тухайн нээхээр төлөвлөсөн хэсэгшлээс үргэлжлүүлэн суналын дагуу чиглэлд хэсэгшлүүдийг дарааллаар нь ашиглана.

- Хүрэн жалгын ордын 3-В хэсэгшлийг нээж тухайн хэсэгшлийг ашиглаж дууссаны дараа 4-В, 5-В, 6-В, 7-В, 2-С, 3-С, 4-С, 5-С, 2-В, 1-В, 1-С гэсэн дарааллаар хэсэгшлүүдийг ашиглахаар байна.

- Цогт жалгын ордын хувьд 1-В хэсэгшлийг нээж тухайн хэсэгшлээс үргэлжлүүлэн 2-В, 1-С, 2-С гэсэн дарааллаар ашиглана.

- Яст жалгын ордын хувьд 1-В хэсэгшлийг нээж тухайн хэсэгшлээс үргэлжлүүлэн 2-В, 2-С, 1-С гэсэн дарааллаар ашиглана.

- Баруун жалгын ордын хувьд 1-С хэсэгшлийг нээж улмаар тухайн хэсэгшлээс үргэлжлүүлэн 1-В, 2-С гэсэн дарааллаар уулын ажлыг явуулна.

- Тогоот дэнжийн ордын хувьд 9-С хэсэгшлийг нээж, тухайн хэсэгшлээс үргэлжлүүлэн 8-С, 7-С, 3-С, 2-С, 1-С, 6-С, 5-С, 4-С гэсэн дарааллаар ашиглана.

- Өвөр дэнжийн ордын хувьд 1-С хэсэгшлийг нээж, тухайн хэсэгшлээс үргэлжлүүлэн 2-С, 3-С, 4-С гэсэн дарааллаар ашиглана.

- Бааст жалганы ордын хувьд 3-С, 2-С, 1-С, 1-В, 2-В гэсэн дарааллаар ашиглана.

- Манж дэнжийн ордын хувьд 1-В хэсэгшлийг нээж, тухайн хэсэгшлээс үргэлжлүүлэн 2-В, 3-В, 1-С, 2-С, 4-С, 3-С гэсэн дарааллаар ашиглана.

- Хавтгай дэнжийн ордын хувьд 1-В хэсэгшлийг нээж, тухайн хэсэгшлээс үргэлжлүүлэн 2-С, 1-С гэсэн дарааллаар ашиглана.

- **Ашиглалтын эхний жил.** Эхний жилд Хүрэн жалгын ордыг бүрэн ашиглахаар төлөвлөв. Хүрэн жалгын ордын 3-В хэсэгшлийн нээлтийн хүрээнээс үргэлжлүүлэн 4-В, 2-В, 1-В, 1-С, 5-В, 6-В, 7-В, 2-С, 3-С, 4-С, 5-С гэсэн хэсэгшлүүдийг олборлосноор ашиглалтын эхний жилийн уулын ажил дуусна.

- Хүрэн жалгын ордын В зэрэглэлийн нөөцийн хэсэгшлүүдийн хөрсийг бульдозероор, С зэрэглэлийн нөөцийн хэсэгшлүүдийн хөрсийг экскаватороор хуулах ба Тогоот дэнжийн ордын 8-С, 9-С хэсэгшлүүдийн хөрсийг экскаватороор хуулж, элс угаах цөөрөм, усан сан, түүний даланг байгуулна.

- Ашиглалтын эхний жилд бульдозероор 51.4 мян.м³ хөрс, экскаватороор 107.7 мян.м³ хөрсийг тус тус хуулна.


- Хүрэн жалгын ил уурхайн эцсийн байдал нь дунджаар 2268 м урт, 70 м өргөн, 1.8 м гүн, уурхайн хажуугийн элсний доголын налуу 70°, хөрсний доголын налуу 16° байна.

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших “Ривади” ХХК-ийн “Манж толгой” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Нийт 182.9 мян.м² талбайд уулын ажлыг явуулж, 159.1 мян.м³ хөрс хуулж, 170.3 мян.м³ элс олборлох ба хөрс хуулалтын дундаж коэффициент 0.93 м³/м³ байна.
- Уулын ажлын хэмжээг хүснэгт 9-д, уулын ажлын эцсийн ерөнхий байдлыг зур.3-т, ашиглалтын 1 дэх жилийн уулын ажлын эцсийн байдлыг хавсралт зураг 6-т тус тус үзүүлэв.

Хүснэгт 8. Ашиглалтын эхний жилийн уулын ажлын тооцоо

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ордын нэр		Нийт
		Хүрэн жалга	Тогоот дэнж /хөрс хуулалт/	
Уулын цулаар	мян.м ³	277.3	52.2	329.4
Үүнээс: Хөрс хуулалт	мян.м ³	106.9	52.2	159.1
Элс олборлолт	мян.м ³	170.3	0.0	170.3
Металлын дундаж агуулга	мг/м ³	169	0	169
Металл /шлих/	кг	28.71	0.00	28.71
Металл /цэвэр/	кг	26.99	0.00	26.99
Хөрс хуулалтын дундаж коэффициент	м ³ /м ³	0.63	0.0	0.93



1-Ашиглалтад өртөөгүй нөөц; 2-шимт хөрсний овоолго; 3-техникийн нөхөн сэргээлт; 4-биологийн нөхөн сэргээлт; 5-гадаргуугийн зам; 6-цэвэр усан сан; 7-эфелийн цөөрөм; 8-баяжуулах цех; 9-нөхөн сэргээсэн талбай; 10-ашиглалтын тусгай зөвшөөрлийн хил; 11-ус дамжуулах шугам хоолой.

Зураг 5. Ашиглалтын эхний жилийн уулын ажлын эцсийн байдал

Ашиглалтын 2 дахь жил. Хоёр дахь жилд Цогт жалгын ордоос эхлэн ашиглах ба Яст жалга, Тогоот дэнж, Баруун жалгын ордуудыг олборлосноор уулын ажил дуусна.

- Цогт жалгын ил уурхайн эцсийн байдал нь дунджаар 1010 м урт, 160 м өргөн, 2.1 м гүн, ил уурхайн хажуу 70° болон 16° налуутай, 101.4 мян.м² талбайтай байна;
- Яст жалгын ил уурхайн эцсийн байдал нь дунджаар 547 м урт, 67 м өргөн, 1.8 м гүн, ил уурхайн хажуу 16° налуутай, 35.3 мян.м² талбайтай байна;
- Тогоот дэнжийн ил уурхайн эцсийн байдал нь дунджаар 1118 м урт, 50 м өргөн, 2.7 м гүн, ил уурхайн хажуу 70° болон 16° налуутай, 50.3 мян.м² талбайтай байна;
- Баруун жалгын ил уурхайн эцсийн байдал нь дунджаар 413 м урт, 38 м өргөн, 2.4 м гүн, ил уурхайн хажуу 70° болон 16° налуутай, 15.8 мян.м² талбайг хамарч байна.

Ашиглалтын эхний жилтэй адил хөрс хуулалтанд бульдозер, экскаваторыг тус тус ашиглана. Ашиглалтын 2 дахь жилд бульдозероор нийт 133.3 мян.м³ хөрс, экскаватороор 106.1 мян.м³ хөрсийг тус тус хуулна.

Нийт 202.8 мян.м² талбайд уулын ажлыг явуулж, 239.4 мян.м³ хөрс хуулж, 173.1 мян.м³ элс олборлох ба хөрс хуулалтын коэффициент 1.38 м³/м³. Уулын ажлын хэмжээ, уулын ажлын эцсийн ерөнхий байдлыг дараах зураг 7-т, ашиглалтын 2 дахь жилийн уулын ажлыг хавсралт зурагт тус тус үзүүлэв.

Хүснэгт 9. Ашиглалтын 2 дахь жилийн уулын ажлын хэмжээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ордын нэр				Нийт
		Цогт жалга	Тогоот дэнж	Баруун жалга	Яст жалга	
Уулын цулаар	мян.м ³	239.5	78.9	32.0	62.0	412.5
Үүнээс: Хөрс хуулалт	мян.м ³	133.0	50.8	18.1	37.5	239.4
Элс олборлолт	мян.м ³	106.5	28.1	14.0	24.6	173.1
Металлын дундаж агуулга	мг/м ³	121.7	75.0	101.3	104.1	110
Металл, /шлихээр/	кг	12.97	2.10	1.42	2.56	19.0
Металл, /цэврээр/	кг	12.19	1.98	1.33	2.41	17.9
Хөрс хуулалтын дундаж коэффициент	м ³ /м ³	1.25	1.81	1.29	1.52	1.38


Ашиглалтын 3 дахь жил. Гурав дахь жилд Бааст жалгын ордоос эхлэн ашиглах ба Өвөр дэнжийн орд, Манж дэнжийн орд, Хавтгай дэнжийн ордыг дараалуулан олборлосноор ашиглалтын 3 дахь жилийн уулын ажил дуусна.

- Бааст жалгын ил уурхайн эцсийн байдал нь дунджаар 490 м урт, 48 м өргөн, 1.6 м гүн, ил уурхайн хажуу 16° налуутай, 23.9 мян.м² талбайг хамарч байна;
- Өвөр дэнжийн ил уурхайн эцсийн байдал нь дунджаар 393 м урт, 50 м өргөн, 4.2 м гүн, ил уурхайн хажуу 70° налуутай, 19.3 мян.м² талбайг хамарч байна;
- Манж дэнжийн ил уурхайн эцсийн байдал нь дунджаар 938 м урт, 61 м өргөн, 3.6 м гүн, ил уурхайн хажуу 70° болон 16° налуутай, 62.8 мян.м² талбаг хамарч байна;
- Хавтгай дэнжийн ил уурхайн эцсийн байдал дунджаар 265 м урт, 46 м өргөн, 3.2 м гүн, ил уурхайн хажуу 70° болон 16° налуутай, 11.6 мян.м² талбай хамарч байна.

Ашиглалтын өмнөх жилүүдтэй адил хөрс хуулалтанд бульдозер болон экскаваторыг тус тус ашиглана. Ашиглалтын 3 дахь жилд бульдозероор 59.4 мян.м³ хөрс, экскаватороор 211.6 мян.м³ хөрс тус тус хуулна.

Нийт 117.6 мян.м² талбайд уулын ажлыг явуулж, 278.5 мян.м³ хөрс хуулж, 98.3 мян.м³ элс олборлох ба хөрс хуулалтын дундаж коэффициент 2.83 м³/м³. Уулын ажлын

тооцоог хүснэгтэнд, уулын ажлын эцсийн ерөнхий байдлыг зурагт, ашиглалтын 3 дахь
жилийн уулын ажлыг хавсралт зурагт тус тус үзүүлэв.




1-Шимт хөрсний овоолго; 2-техникийн нөхөн сэргээлт; 3-биологийн нөхөн сэргээлт; 4-гадаргуугийн зам; 5-цэвэр усан сан; 6-эфелийн цөөрөм; 7-галийн овоолго; 8-баяжуулах цех; 9-нөхөн сэргээсэн талбай; 10-ашиглалтын тусгай зөвшөөрлийн хил; 11-ус дамжуулах шугам хоолой.

Зураг 6. Ашиглалтын 2 дахь жилийн уулын ажлын эцсийн байдал

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших “Ривади” ХХК-ийн “Манж толгой” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Ашиглалтын 3 дахь жилийн уулын ажлын тооцоо

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ордын нэр				Нийт
		Бааст жалга	Өвөр дэнж	Манж дэнж	Хавтгай дэнж	
Уулын цул	мян.м³	32.2	81.2	228.7	34.8	376.9
Хөрс хуулалт	мян.м³	15.0	69.6	171.5	22.4	278.5
Элс олборлолт	мян.м³	17.1	11.6	57.2	12.4	98.3
Дундаж агуулга	мг/м³	91	62	134	163	122
Металл, /шлих/	кг	1.55	0.72	7.67	2.03	11.97
Металл, /цэвэр/	кг	1.46	0.68	7.21	1.91	11.26
Хөрс хуулалтын дундаж коэффициент	м³/м³	0.88	6.02	3.00	1.81	2.83



1-Ашиглалтад өртөөгүй нөөц; 2-шимт хөрсний овоолго; 3-биологийн нөхөн сэргээлт; 4-нөхөн сэргээсэн талбай; 5-гадаргуугийн зам; 6-ашиглалтын тусгай зөвшөөрлийн хил; 7-кемп.

Зураг 8. Ашиглалтын 3 дахь жилийн уулын ажлын эцсийн байдал


Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Нийт ил уурхайн хил хязгаар доторх хөрс хуулалт 677.0 мян.м, үйлдвэрийн элсний нөөц 441.8 мян.м³. Тус ордыг 3 жилийн хугацаанд ашиглах ба уулын ажлын төлөвлөлтийг 1, 2, 3 дахь жилийн ашиглалтын эцсийн байдлын хил хязгаарын хүрээнд хийгдсэн тооцоо, зургуудыг үндэслэн 3 үе шатаар харуулав. Уурхайн төлөвлөлтийн жилүүдийн уулын ажлын тооцоог хүснэгт 12-т, ерөнхий байдлыг дараах зураг 9-д тус тус үзүүлэв.

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших “Ривади” ХХК-ийн “Манж толгой” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 11. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жил			Нийт
			1	2	3	
1	Уулын цулаар	мян.м³	329.4	412.5	376.9	1118.8
2	Үүнээс: Хөрс хуулалт	мян.м³	159.1	239.4	278.5	677.0
	шимт хөрс	мян.м³	33.3	40.6	23.5	97.3
3	Элс олборлолт	мян.м³	170.3	173.1	98.3	441.8
4	Металлын дундаж агуулга	мг/м³	168.6	110.0	121.8	135.2
5	Алтны нөөц (шлихээр)	кг	28.71	19.04	11.97	59.73
6	Алтны нөөц (цэврээр)	кг	26.99	17.90	11.26	56.15
7	Хөрс хуулалтын дундаж коэфф.	м³/ м³	0.93	1.38	2.83	1.53




Зураг 7. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

1.5 Баяжуулалт

1.5.1 Баяжуулах технологи

Ордыг төлөөлүүлэн ирүүлсэн 626 кг (Хүрэн жалгын орд 296 кг, Манж толгой орд 330 кг) дээжинд Геологийн судалгаа, шинжилгээний төв ТӨҮГ-т хийлгэсэн технологийн бүдүүвчийг сонгон авав (зур.№ III.2). Хүрэн жалгын ордод хийсэн технологийн туршилтын үр дүн нь ордыг төлөөлөх чадвар багатай гарсан тул Манж толгойн ордын технологийн туршилтын тайлангийн үр дүнг баяжуулалт бүлгийн тооцоонд ашиглав. Элс угаах тоног төхөөрөмжийн хувьд хүндийн хүчний тоног төхөөрөмжийг ашиглана. Ангилан ялгах болон шлюзийн хослол, гүйцээн баяжуулалтанд сэгсрэх ширээ зэрэг үндсэн тоног төхөөрөмжийг ашиглана.



1.5.2 Баяжуулах цехийн ажиллах горим, хүчин чадал

Хүчин чадал: Техникийн даалгаврын дагуу тус баяжуулах цехэд ПГШ-80 маркийн скруббер бүхий угаах төхөөрөмжийг ашиглана. Угаах тоног төхөөрөмж, ажиллах горимоос хамааруулан жилийн хүчин чадлыг тодорхойлов.

$$Q_{\text{ж}} = Q_{\text{ц}} \cdot N \cdot t \cdot k = 173.0 \text{ мян.м}^3/\text{жил}$$

энд: $Q_{\text{ц}}$ -цагийн хүчин чадал; $Q_{\text{ж}}$ -жилийн хүчин чадал; N -жилд ажиллах хоног; t -хоногт ажиллах цаг; k -цаг ашиглалтын коэффициент.

Ажиллах горим: Баяжуулах цехийг дулааны улиралд буюу 6-р сарын 4-өөс 9-р сарын 30-ны хооронд 106 хоногийн хугацаанд 8 цагийн үргэлжлэлтэй 3 ээлжээр үйл ажиллагаа явуулахаар төлөвлөв. Ашиглалтын 3 дахь жилд 60 хоног ажиллахаар байна.

Хүснэгт 12. Баяжуулах цехийн ажиллах горим

№	Ажиллах горим	1 дэх жил	2 дахь жил	3 дахь жил
1	Жилийн хуанлийн хоногийн тоо	365	365	365
2	Жилд ажиллах хоног	106	106	61
3	Хоногт ажиллах ээлжийн тоо	3	3	3
4	Ээлжид ажиллах цаг	8	8	8
5	Цаг ашиглалт, %	85	85	85
6	Жилд ажиллах цаг	2162	2162	1244
7	Цагийн хүчин чадал, м³/цаг	80	80	80

Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших “Ривади” ХХК-ийн “Манж толгой” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

8	Ээлжийн хүчин чадал, м³/ээлж	544	544	544
9	Хоногийн хүчин чадал, м³/хоног	1632	1632	1632
10	Жилийн хүчин чадал, мян.м³/жил	173.0	173.0	99.6

Баяжуулах технологийн тоо-чанар, ус-шлагын тооцоо

Тоо-чанар: Технологийн процесс бүрд бүтээгдэхүүний тоо-чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох ба технологийн схемийн тоо-чанарын үзүүлэлтийн тооцоог хүснэгтэнд үзүүлэв.

$$\text{Баяжмалын минерал авалт: } \varepsilon_{\beta} = \frac{\gamma_{\beta} \cdot \beta}{\alpha}, \%$$

$$\text{Хаягдлын минерал алдалт: } \varepsilon_{\alpha} = \frac{\gamma_{\alpha} \cdot \theta}{\alpha}, \%$$

$$\text{Хаягдал болон баяжмалын гарц: } \gamma_{\beta} + \gamma_{\alpha} = 100 \%$$

энд: ε_{β} , ε_{α} - баяжмал болон хаягдал дахь алтны хэмжээ, %; γ_{β} , γ_{α} - баяжмал болон хаягдлын гарц, %; α - анхдагч элсний агуулга, %; β - баяжмал дахь алтны агуулга, %; θ - хаягдал дахь алтны агуулга, %

Ус-шлаг: Ус-шлагын тооцоог доорх томъёогоор тооцон баяжуулахад шаардлагатай усны хэмжээ, зарцуулалтыг гаргаж хүснэгт 9-д үзүүлэв.

$$\text{Бүтээгдэхүүний усны хэмжээ: } W_n = R_n \cdot Q_n, \text{ м}^3/\text{цаг}$$

$$\text{Булангийн эзлэхүүн: } V_n = Q_n \cdot \left(R_n + \frac{1}{\delta} \right), \text{ м}^3/\text{цаг}$$

$$\text{Бүтээгдэхүүний хатуулаг: } S_n = \frac{100}{1 + R_n}, \%$$

энд: Q_n - хүчин чадал, т/цаг; R_n - бүтээгдэхүүн дэх хатуу шингэний харьцаа, %; Δ - бүтээгдэхүүний хувийн жин, г/см³; W_n - бүтээгдэхүүний усны хэмжээ, м³/цаг; V_n - булингийн эзлэхүүн, м³/цаг; S_n - бүтээгдэхүүний хатуулаг, %

1.6 Дэд бүтэц


Ус хангамж	Талбай нь Хангайн нурууны урд хэсгийн Жаргалантын салбар уулын өвөр бэлийн усан сүлжээ муу хөгжсөн дунд, нам уулс, ухаа толгод, хуурай хөндийн бүсэд харьяалагдана. Гүний болон хөрсний усны тэжээгдэл нь талбайн ЗХ, хойд хэсгээс БХ сунаж тогтсон 2500-2700 м үнэмлэхүй өндөртэй Дөвөнтийн нуруунд ордог хурын усны зөөгдлөөр үүсэж доод цэрдийн нүүрс агуулсан тунамал, мезопротерозойн Өлзийтгол формацын метаморф чулуулгийн хагарал дагуух ~100-150 м өргөн бутралын бүсийн дагуу хуримтлагдана. Баруун хойш чиглэсэн Мөнгөө нурууны хагарлын мөргөцөгт 3 м гүн малтсан /Баяндаваа, Цахир/ 2 худагтай. Худгийн ус нь амт, үнэргүй, унданд хэрэглэдэг. Тус худгаас унд ахуйндаа хэрэглэхээр төсөлд тусгав. Худгийн ус нь ГОСТ-2874-82 стандартын шаардлагад нийцсэн, 90 м гүнтэй, усны ундарга 1.8 л/с, ЭЦВ 8-25-150 маркийн насосоор тоногдсон байна. Ан цавын уст давхаргууд Манж толгойн өвөр бэлээр БХ чиглэсэн хагарал дагуу задгайрч, тэнд гар аргаар малтсан 5 м гүнтэй гар худаг 1980 он хүртэл ажиллагаатай байсан. 1982 онд “Монголболгарметалл”-ийн гидрогеологич З.Крыстогийн удирдлагаар гаргаж, өнөөг хүртэл тасралтгүй ажиллаж байна. Тус худгийн ундарга 43 л/с байна. Тус худгийн усыг унданд ашиглах боломжгүй тул технологийн усны хэрэгцээнд ашигладаг. Мөн технологийн усны хэрэглээнд нэмж 2 ш гүний худаг гарган хангахаар төлөвлөв. Баяжуулах цехийг усаар тасралтгүй хангах зорилгоор цэвэр усан сан байгуулж, дээрх 2 худгаас ус татаж хуримтлуулна. Баяжуулах цех №2, гүний худаг хоёрын дунд хэсэгт цэвэр усан сан байгуулахаар төлөвлөв. Тус усан сан нь технологийн усны 7 хоногийн нөөцийг хангах багтаамж бүхий 3 м гүн, 3620 м² талбайтай байна. Усан сангаас баяжуулах цехийн цэвэр усны ёмкость хүртэл татах үндсэн дамжуулах хоолойн урт /хамгийн урт байх нөхцөлөөр/: гүний худаг 280 м; баяжуулах цех №1-ээс 2400 м; баяжуулах цех №2-оос 300 м; нийт 2980 м ба тэдгээрийн диаметр 125 мм байхаар сонгов. Ус дамжуулах хоолой нь SDR13.6 стандартын 1.25МПа даралт тэсвэрлэх чадвартай, ханын зузаан 18.4 мм, полиэтилен хоолой (PE хоолой) байна.
-------------------	---

Засвар, техник үйлчилгээ	Засвар техникийн үйлчилгээний дэд бүтцийн зориулалтыг дараах байдлаар авав. Үүнд:
---------------------------------	--

	1. Уулын механик тоног төхөөрөмжийн агрегатын засварын хэсэг, зөөврийн засвар техникийн үйлчилгээний бригадын хамт 2. Автомашины агрегатын засвар техникийн үйлчилгээний хэсэг 3. Механик цех 4. Цахилгаан тоноглолын засварын хэсэг 5. Материал сэлбэгийн агуулах. Засвар, техникийн үйлчилгээний газрын хэсгийн зориулалт 1. Агуулах нь уурхайн үндсэн тоног төхөөрөмж, тээврийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, бусад туслах материалуудыг хадгалах зориулалттай. Зарим том овортой сэлбэг материалыг агуулах байрны гадна талд тусгай газар хадгална. 2. Дугуй засварын газрыг бие даасан байгууламж байдлаар тусгаагүй. Дугуй солих хөдөлгөөнт үйлчилгээ нэвтрүүлсэн нь байнгын суурин цех ажиллуулснаас давуу талтай. Автосамосвалуудын дугуй хагарсан тохиолдолд хөдөлгөөнт үйлчилгээ нь байгаа газар нь очиж дугуйг засварлана. Засварын цехийн ойролцоо дугуй шалгах, солих, засварлах үйл ажиллагаа явуулах зорилгоор хатуу хучилттай суурь хийх шаардлагатай.
--	--

Цахилгаан хангамж	Захиалагчийн техникийн даалгаврын дагуу дизель цахилгаан үүсгүүр ашиглахаар төлөвлөж, тооцоолж ТЭЗҮ-д тусгасан байна. Цахилгаан хэрэглэгчид нь өөр хоорондоо зайтай байрлах тул тус тусад нь зөөврийн дизель цахилгаан үүсгүүрээр цахилгаан эрчим хүчээр хангана. Тус ордын ашиглалтанд дараах нэр бүхий хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангана. Үүнд: • Баяжуулах цехийн хэрэглэгчид: Угаах төхөөрөмж, сэгсрэх ширээ, эргэлтийн усны насос, гүний худгийн насос. • Кемпийн хэрэглэгчид: Захиргааны байр, ажиллагсдын байр, хоолны газар, ахуй үйлчилгээний газар, засварын газар, ШТС гэх мэт. Дээрх бүх хэрэглэгчид нь 0.4 кВ-ын цахилгаан эрчим хүчээр хангагдана.
-------------------	--

Барилга байгууламж	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн булангийн цэг №3-ын баруун буланд Монгол Болгар ХХК нь 4.0 га талбайд кемп байгуулж, ашиглаж байсан байна. Захиалагч компани нь өөрийн ашиглалт дууссан уурхайгаас барилга байгууламжуудыг шилжүүлж, тус талбайг ашиглаж, кемп байгуулна. Кемпийн талбайд ажиллагсдын амрах байр 1 ш сэндвич сууц, удирдлагын байр 1 ш контейнер байр, ИТА-ын оффисын байр 1 ш вагон сууц, хоолны газар 1 ш сэндвич байр, ахуйн үйлчилгээний 3 ш гэр, спорт комплексын төв 1 ш сэндвич байр зэрэг барилга байгууламжийг шилжүүлэх ба сэлбэгийн агуулах 40 т-ын 2 ш контейнер, дэд бүтцийн шугам зэрэг бусад барилга байгууламжийг шинээр авч байрлуулна. Кемпийн талбайн баруун жигүүрт хүлэмж, хүнсний ногооны агуулах, тухайн жилийн уулын ажил зогсоход уулын тоног төхөөрөмжийг байршуулах, ашиглалтын үед засвар үзлэг хийх зориулалттай талбайг хойд жигүүрт байгуулахаар төлөвлөв.
--------------------	---



2. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Газрын гадарга, хэвлий. Тус талбай нь физик газар зүйн мужлалаар Хангайн их мужийн хангайн өмнөд бэгэлцэг тойрогт хамаарагдана. Баянхонгор аймаг нь Монголын баруун өмнөд хэсэгт Хангайн нурууны өмнөх өндөрлөг, Говь Алтайн нурууны уулс, Алтайн өврийн говийг хамран говь хангайн бүсийг дамнан оршдог юм. Тусгай зөвшөөрлийн талбай нь намхан уулс, дов толгодлог, хөндийд байрлах ба ерөнхийдөө намхавтар гадаргуутай, гадаргуугийн тогтмол урсацтай гол горхигүй байна. Газрын гадаргын харьцангуй өндөр нь далайн түвшнээс дээш 2117 м-т хэлбэлзэх ба харьцангуй өндөршил 1400 м орчим. Иймд нутаг нь хангай говь хосолсон хэлбэр бүхий гадаргатай юм.

Дөвөнтийн нурууны өвөр хэсгийн далайн түвшнээс дээш 2200-2600 м өндөрт өргөгдсөн нам, дунд уулс, тэдгээрийг зааглагч цэрдийн нүүрс агуулагч хотгор, хойноос урагш чиглэсэн хуурай жалгуудтай.

Уур амьсгал. Сэрүүн зун, хавсаргатай хавар, хүйтэн өвөлтэй. Сүүлийн 30 жилд ороогүй бороо 2023 оны 6, 7, 8-р сард орж, хуртай зун болж, жалгуудаас хадлан бэлтгэх хэмжээнд /30-40 см/ өвс ургасан. Жилийн дундаж хур тунадас орох зузаан 250-300 мл.

Галуут сумын нутагт 2012-2021 оны агаарын дундаж температур -5.0...-2.1 °C-ын хооронд хэлбэлзсэн бөгөөд өвлийн улиралд -30.4...-17.4°C, хаврын улиралд -13.2...+9.5°C, зуны улиралд +11.4...+18.0°C харин намрын улиралд -17.3...+10.4°C хүрсэн байна. Тухайн бүс нутагт жилд орох хур тунадасны нийлбэр 125.8...311.3 мм-ийн хооронд хэлбэлзэх бөгөөд улирлаар авч үзвэл өвлийн улиралд 1.4...2.6 мм, хаврын улиралд 2.8...9.4 мм, зуны улиралд 33.8...66.9 мм, намрын улиралд 3.9...28.1 мм-ийн хооронд унадаг байна.

Харьцангуй чийгшлийн жилийн явцын хамгийн их утга нь өвлийн улиралд 76%, дараагийнх нь зуны улиралд 63% хүрч тус тус ажиглагдана. Харин хамгийн бага утга нь хавар 25%, дараагийнх нь намар 39% хүрч тус тус тохиолдоно. Эндээс үзвэл өвлийн хахир хүйтэн үе болон зуны хур тунадасны хэмжээнээс шалтгаалан агаарын чийгшил нэмэгддэг бол хавар, намрын улиралд дулааны өсөлт түргэн бөгөөд хөрсний нөөц чийг дутмаг байх учир агаар ихээхэн хуурай болдог нь харагдана..

Судалгаанд хамрагдаж буй нутагт салхины хурд жилд дунджаар 2.1 м/с байсан бөгөөд хавар, намрын улиралд өсөж өвөл, зуны улиралд буурсан байна. Хамгийн их утга нь 5 сард дунджаар 4.4 м/с бол хамгийн бага утга нь 1 сард дунджаар 0.5 м/с ажиглагдсан байна. Салхины зүг чиглэлийн давтагдал нь тухайн орон нутгийн физик газарзүйн тогтолцооны нөлөөлөлтэй.

Галуут сумын салхины зүгийн давтагдал нь жилийн 4 улиралд хойно, зүүн хойно зүгийн салхи 10-18%-иар зонхилдог бол баруун хойд зүгийн салхи 11-17%-иар бусад зэргэлдээх зовхисоос их давтагддаг байна.

Агаарын чанар. Баянхонгор хотын агаарын бохирдлыг хянах харуулын дүнгээс үзэхэд 01 дүгээр сарын 02-с 01 дүгээр сарын 06 -нийг хүртэлх дундаж агууламж хүхэрлэг хий /SO₂/-0.051 азотын давхар исэл /NO₂/-0.042 тоосонцор /PM_{2.5}/-0.062мкг/м³ байна. Гадаад орчны MNS4585-2016 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/, тоосонцор /PM_{2.5}/ давж бохирдоогүй байна. Харин жижиг ширхэглэгт тоосонцор /PM_{2.5}/ стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлттэй байна.

Геологийн тогтоц ба геоморфологи. Мезопротерозойн насны метаморф, цэрдийн тунамал, плиоценийн улаан, дөрөвдөгчийн саарал өнгөт сэвсгэр хурдсууд тархсан.

Геоморфологи. Талбай нь Хангайн нурууны өмнөд хэсгийн баруун хойш сунасан Жаргалантын нурууны өвөр бэлийн 2200-2600 м өндөртэй нам, дунд уулсын бүсэд багтана. Хойноосоо урагш уулс нь шатлан намсаж нуурын хөндийд шилжинэ. Талбайд зөөгдөл-хуримтлалын, тектоник-элэгдлийн гэсэн үндсэн 2 гадаргуу ялгаж тэдгээрийн доторх бичил хэвүүдийг онцолж тэмдэглэв. Талбайн хойд хэсэг нь өндөр, төв хэсэг нь дунд, уул хооронд нь мезозойн хотгор, урд хэсэг нь кайнозойн нуурын дэнж, хөндийгөөс тогтоно. Дунд уулс нь элэгдэж пенеплен, нам уулс нь педимент тэгш гадаргуунууд үүсгэнэ. Талбайн төв хэсгийн нам уулын тэгшрэлийн гадаргуу дээр плиоцений эртний голын үлдэгдэл дэнжүүдтэй ба орчин цагийн сайрууд нь зүүн хойноос баруун урагш чиглэсэн.

Тектоник. Тектоник структурын байршлаараа Хангайн нурууны өвөр бэлийг эмжсэн Баянхонгорын офиолит бүсийн хэмжээн дэх БХ чиглэсэн Мөнгөө нуруу, Баянхонгорын хагарлуудаар тусгаарлагдсан Жаргалант, Өлзийт, Бүрд террейнүүдэд хуваагдана. Талбайн төв хэсгээр Мөнгөө нуруу, Баянхонгор хагарлуудаар доош суусан нүүрс агуулагч цэрдийн хурдаст Манжийн грабень хотгор үүсжээ. Талбайд эх газрын захын нум, арлан нумын метаморф, далайн царцдасын хэт суурилаг меланж, эх газрын идэвхтэй зах, коллизын боржинлогууд, эх газрын рифтийн хотгор, плиоцений гол, гол-хормойн үлдэгдэл дэнжүүд, орчин цагийн сайрын сэвсгэр хурдас тархсан. Орчин цагт өргөгдөл голлож тэгшрэлийн гадаргуу үүсэж алт агуулагч хувирлын бүсүүд, судлууд, плиоцений голын хурдаст үлдэгдэл дэнжүүд угаагдаж жалганы жижиг шороон ордууд үүсжээ.

Гадаргын болон газрын доор ус. Төслийн талбай нь ус зүйн хувьд Төв азийн гадагш урсгалгүй ай сав, Бөөнцагаан нуур- Байдраг голын сав газарт багтана.

Талбайг хамарсан мезопротерозойн Жаргалант, Өлзийтгол, Бүрдийнгол формацын шохойжингийн үеүдтэй ногоон занар, метаэлсжин, доод цэрдийн нүүрс агуулагч тунамал чулуулаг дахь ан цавын, плейстоцен, плиоцен, голоцены сэвсгэр хурдас дахь нүх сүвийн уст давхаргууд ялгагдана. Ан цавын уст давхаргууд Манж толгойн өвөр бэлээр БХ чиглэсэн хагарал дагуу задгайрч, тэнд гар аргаар малтсан 5 м гүн худаг 1980 он хүртэл ажиллагаатай байв. 1982 онд “Монголболгарметалл” үйлдвэрийн Сайрын худаг, Мухар эрэг, Өвөр чулуутын алтны шороон ордыг ашиглахад хүрэлцэхүйц ундаргатай (43 л/с) худгийг Болгарын гидрогеологич З.Крыстогийн удирдлагаар гаргаж, эдүүгээ 42 жил тасралтгүй ажиллажээ.

Плиоцений үлдэгдэл дэнжүүдэд хөрсний ус, олон жилийн цэвдэг илрээгүй. Хүрэн, Яст, Цогт, Бааст жалгуудад хөрсний ус, олон жилийн цэвдэггүй. Харин Яст, Цогт жалгуудыг огтолсон Баянхонгорын БХ чиглэсэн хагарлуудын мөргөцгөөс зөвхөн хуртай жил 0.5-1.0 л/с ундаргатай жижиг булгууд ундарч 10-20 м урсаад шургадаг. Гүний болон хөрсний усны тэжээгдэл нь талбайн ЗХ, хойд хэсгээрх БХ сунаж тогтсон 2500-2700 м үнэмлэхүй өндөртэй Дөвөнтийн нуруунд орсон хурын усны зөөгдлөөр үүсэж доод цэрдийн нүүрс агуулсан тунамал, мезопротерозойн Өлзийтгол формацын метаморф чулуулгийн хагарал дагуух ~100-150 м өргөн бутралын бүсийн дагуу хуримтлагдана. Манж толгойн өвөр бэлээрх БХ чиглэсэн хагарал дагуу хоорондоо 1.5 км зайтай байрлах 2 өрөмдмөл худаг байна. Ус нь хэт хатуу, гидрокарбонат найрлагатай тул унданд тохирохгүй, ахуйн болон техникийн хангамжид тохирно.

Хөрсөн бүрхэвч. Талбайд бор хөрс зонхилох ба Манж толгойн өвөр бэлээр хужир марз бүхий саарал хөрстэй бөгөөд дэрс, монгол өвс, шарилж зонхилдог. хөрсний ялзмагийн хэмжээ 0-20 см-ийн гүнд ялзмагийн хэмжээ 0.61-2.34 байна. Энэхүү үзүүлэлт нь Монголын уулархаг хээрийн бүсийн уулын хүрэн хөрсний дундаж үзүүлэлттэй нийцэж байна. Уусмалын орчин (рН) 8.19-8.55 буюу “шүлтлэг” шинж чанартай байна. Давсжилт (0.02-0.44) бага, 0-20 см-т карбонаттай учраас цахилгаан дамжуулах чадвар (ЦДЧ) сул (0.041-1.094 dS/m) байна. Энэ бол намхан уулс дунд тогтворжсон тэгш тал газарт хуримтлагдсан делюв-пролювын гарал үүсэлтэй хурдас дээр тогтворжсон тал хөндийн хөрсний үндсэн шинж болохыг гэрчилж байна. Солилцох сууриудын нийлбэр А давхаргад 25-27 мг-экв/100г байж, энэхүү тоон утга тус хөрсөнд “хэвийн” байна. Шим тэжээлийн бодис болох хөдөлгөөнт фосфор 2.7-4.6 мг-экв/100г, калийн агууламж 18-34 мг-экв/100г байгаа нь дунд-сайн агууламжтай байна.

Ургамлан бүрхэвч. Монгол орны ботаник газарзүйн мужлалаар хуурай хээрийн бүсэд хамаарна.

Талбайн хэмжээнд хамгийн өндөр өргөгдсөн цэг нь талбайн урд, зүүн урд захаар орших далайн түвшнээс дээш 2350м-т, хамгийн намхан цэг нь 1300 м-ийн өндөртэй байх бөгөөд харьцангуй өндөршилт 50-150м орчим байна. Толгодууд, гүвээ нь мөлгөр оройтой, аажим налуу хажуутай, уужим тавиу өргөн хөндий хөгжсөн байдаг. Уулын хээрийн хөрсний бүсэд багтана. Өвс үетэнт, хялганат, хазааргана- хялганат, агь- хялганат, монгол өвс, хазаар өвс, шарилж, ерхөг зэрэг нэг наст болон олон наст ургамал ургадаг. Уулын хээрт голдуу үет ургамал зонхилох боловч хөрс газрын гадаргатай уялдан олон зүйл үетний эзлэх хувь өөр өөр болсноор хээрийн үндсэн эвслүүдээс ялгагдана.

Энэ тойрог БНМАУ-ын нутаг дэвсгэрийн 11.54 %-ийг эзэлнэ. Амьдралын хэлбэрийн хувьд 1498 зүйл өвслөг ургамал үүнээс 1292 зүйл олон настан, 206 зүйл нэг настан 219 зүйл модлог сөөглөг ургамал ургадаг байна (Өлзийхутаг, 1989).

Амьтны аймаг. Амьтны аймгийн судалгааг газар дээр нь очиж нарийн тооцоолох боломжгүй тул Монгол орны үндэсний атлас, Монгол орны хөхтөн амьтны Улаан данс болон бусад холбогдолтой ном зохиол ашиглан хийсэн болно. Газрын гадарга нь дунд зэргийн өндөр толгодоор хүрээлэгдсэн гүвээ талархаг байдалтай. Төсөл хэрэгжих орчим жижиг хөхтөн амьтад ойр орчимд цөөн тоогоор тааралддаг бөгөөд Улаан данс (2006)-ны ангилал болон Монгол улсын болон олон улсын хууль тогтоомж, конвенцуудын хавсралтад орсон ховор зэрэглэлийн болон агнуурын ач холбогдолтой хөхтөн амьтан байхгүй буюу анхааралд өртөхөөргүй зүйлүүд байна.

Тусгай хамгаалалттай газар нутаг. Баянхонгор аймгийн Галуут суманд 2 улсын тусгай хамгаалалттай газар, Галуут суманд 34 орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгууд байрласан байна. Төслийн талбай нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.

